



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, 35 дугаар зүйлийн 35.6, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын болон гадаадын 18-аас дээш насны иргэнийг сайн дурын үндсэн дээр коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины 4 дүгээр тунгаар вакцинжуулах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дархлаа сэргээх нэмэлт гурван тунд хамрагдсан, гурав дахь тунг тарьснаас хойш гурван сар өнгөрсөн болон вакцины үйлдвэрлэгчийн зааварт заасан хугацааг баримтлан шалгуурт нийцэх иргэнийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер үйлдвэрийн "Комирнэти", Синофарм/ВІВР үйлдвэрийн "СоrV" вакцинаас сонголт хийлгэн, 4 дүгээр тунгаар вакцинжуулсугай.

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины 4 дүгээр тунгаар вакцинжуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д, вакцины сургалт, сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д, вакцинжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, цэгийн тоог нэмэгдүүлэх, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220031